

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны дугаар сарын –ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулахад Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн анги, төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Журам нь Олон улсын эрэн хайх, аврах баг болон хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд зориулагдаагүй болно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. “Аврагч” гэж “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 4.4-д заасныг;

2.2. “Ажиллагааны үе шат” гэж “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 6-д заасныг;

2.3. “Аврах ажиллагааны даалгавар” гэж эрэн хайх, аврах ажиллагааны гүйцэтгэлийн баримт бичгийг;

2.4. “Ажиллагааны тэмдэглэл” гэж ажиллагааны явц, цагийн байдлын үнэлгээ болон удирдлагын үүрэг чиглэл, шийдвэр гаргалтыг баримтжуулахыг;

2.5. “Ажиллагааны илтгэх хуудас” гэж ажиллагааны үе шат бүрийн гүйцэтгэсэн ажил үүргийн явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилгоор үйлдсэн албан бичиг баримтыг;

2.6. “Ажиллагааны ярилцлага” гэж аврах ажиллагааны дараах оролцогч нарын хооронд холбогдох эрх зүйн баримт бичгийг баримталсан, баталсан төлөвлөгөө, тактик, шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн эсэх, болзошгүй үүсэж болох

эрсдэлийн асуудлыг хэлэлцэх, туршлага, сургамжийг нэвтрүүлэх зорилгоор харилцан яриаг тусгай дэгийн дагуу зохион байгуулахыг;

2.7. “Буцалтгүй нэрвэгдэгч” гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас осолдсон амьд бус (нас барсан), хохирсон иргэн (хүний цогцос)-ийг хэлнэ;

2.8. “Гамшгаас хамгаалах алба” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг эрхэлсэн салбарын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг түшиглэн байгуулсан орон тооны бус томилгоот нэгжийг;

2.9. “Мэргэжлийн анги” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д заасныг;

2.10. “Нэрвэгдэгсэд” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасныг;

2.11. “Сайн дурын хэсэг” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18-д заасныг;

2.12. “Төрийн бус байгууллага” гэж Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллагыг;

2.13. “Цагийн байдал” гэж эрэн хайх, аврах ажиллагааны үүссэн нөхцөл түүний явцад гарсан өөрчлөлтийг;

2.14. “Эрэн хайх, аврах ажиллагаа” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-д заасныг;

2.15. “Эрэн хайх, аврах ажиллагааны шуурхай удирдлагын байр” гэж эрэн хайх, аврах ажиллагааг хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр удирдаж буй ажлын байрлалыг;

2.16. “Эрэн хайх, аврах ажиллагааны даргын ажлын зураг” гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед байр зүйн зураг дээр тулгуурлан эрэн хайх, аврах ажиллагааг төлөвлөх, байршил /GPS/ буюу орон зайн мэдээллийн системийг ашиглан тактикийн таних тэмдэг, тайлбарлах бичгийн тусламжтай буулган зурж хөтөлж байгаа тусгай зориулалтын зургийг;

2.17. “Эрэн хайх, аврах ажиллагааны шийдвэрийн зураг” гэж авсан үүрэг, цагийн байдлын үнэлгээ болон удирдлагын үүрэг чиглэлийн үндсэн дээр аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрийг байр зүйн зурагт буулгахыг;

2.18. “Эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч” гэж “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 4.1-д зааснаар;

2.19. “Эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч” гэж “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 4.2-т зааснаар;

2.20. “Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч” гэж “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 4.3-д зааснаар тус тус ойлгоно.

Гурав. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдлага

3.1. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдлага нь эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, ахлах удирдагч, ерөнхий удирдагчийн түвшинд хэрэгжинэ. Үүнд.

3.1.1. “Эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч” (Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн Ажиллагааны удирдлага, зохицуулалт болон эрэн хайх, аврах ажиллагааны асуудал хариуцсан нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн болон Үндэсний аврах бригад, бүс орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч) нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргад захирагдана.

3.1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга голомтын бүсэд ерөнхий удирдагчаар ажиллаж байгаа тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны шуурхай штабын даргад захирагдана.

3.1.3. “Эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч” (Үндэсний аврах бригад, бүс болон орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Эрэн хайх, аврах анги, салбарын захирагч) нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн Ажиллагааны удирдлага, зохицуулалт болон эрэн хайх, аврах ажиллагааны асуудал хариуцсан нэгжийн даргад захирагдана.

3.1.4. “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 7.4.4, 8.5-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын мэргэшсэн туршлагатай аврагч нь эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчаар ажиллаж болно.

3.2. Аврах бүлгийн дарга болон аврах ажиллагааны мэргэжилтэн (эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч) нь харьяалах аврах анги, салбарын захирагчид захирагдана.

3.3. Аврах анги, салбарын захирагч (эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч) нь харьяалах Үндэсний аврах бригад болон бүс, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын (эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч) дарга, захирагчид захирагдана.

3.4. Энэ журмын 3.2, 3.3-д заасан албан тушаалтныг харьяалах Үндэсний аврах бригад болон бүс, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх нэгжийн захирагч нарыг үүрэгжүүлнэ.

3.5. Ослын голомтод эхний хүрэлцэн ирсэн аврах бүлгийн дарга эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч байна.

3.6. Хүч нэмэгдүүлэн нэмэлтээр ирсэн аврах бүлэг, салбарын захирагч болон эрх бүхий албан тушаалтан удирдлагыг албан ёсоор шилжүүлэн аваагүй тохиолдолд эхний бүлгийн дарга удирдагч байна.

3.7. “Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч”-ийн хүсэлтийг үндэслэн нэмэлт эсхүл сэлгэх хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх асуудлыг харьяалах аврах анги, салбарын захирагч шийдвэрлэнэ.

3.8. “Эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч”-ийн хүсэлтийг үндэслэн нисгэгчгүй нисэх төхөөрөмж, эрэлч нохой болон холбогдох техник, хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх асуудлыг Үндэсний аврах бригад, бүс, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар шийдвэрлэнэ.

3.9. “Эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч”-ийн хүсэлтийг үндэслэн агаарын хөлгөөр дэмжлэг үзүүлэх асуудлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга шийдвэрлэнэ.

3.10. Аврах анги, салбарын захирагч (эрэн хайх, аврах ажиллагааны ахлах

удирдагч) нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн Ажиллагааны удирдлага, зохицуулалт болон эрэн хайх, аврах ажиллагааны асуудал хариуцсан нэгжийн дарга, холбогдох ахлах мэргэжилтэн нараас мэргэжил арга зүйн дэмжлэг, ажиллагааны чиглэлийг авч ажиллана.

3.11. Энэ журмаар нарийвчлан зохицуулагдаагүй ажиллагааны удирдлага, зохицуулалтын асуудлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлага, зохицуулалтын заавар”-ыг удирдлага болгож ажиллана.

Дөрөв. Эрэн хайх, аврах ажиллагааны зохион байгуулалт

4.1. Үндэсний аврах бригад, Агаараас эрэн хайх, аврах нэгж, Уул уурхайн аврах нэгж, Эрэлч нохойн сургалтын нэгж болон бүс, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нь эрэн хайх, аврах ажиллагаанд 72, 144, 216, 288 цаг ажиллах хүнс, шатахууны нөөц (хувцас, багаж хэрэгсэл гэх мэт)-ийг бүрдүүлэн, нутаг дэвсгэрийн байршил, газар зүйн онцлог, цар хүрээнээс хамаарч шаардагдах хүч хэрэгслийг “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” байгууллагын стандартын 9-д зааснаар дайчлан гаргах ажлыг зохион байгуулна.

4.2. Үйлчлэх хүрээнд ажиллаж буй бүрэлдэхүүнд хүч хэрэгсэл нэмэгдүүлэх, эгүүлэн татах, ээлж солих ажлыг харьяалах эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагчийн шийдвэрээр эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч хариуцан зохион байгуулна.

4.3. Эрэн хайх, аврах анги, салбарын захирагч нь эрэн хайх, аврах бүлгүүдийг “Үндсэн”, “Бэлтгэл”, “Нэмэлт”, “Нөөц” хэлбэрээр төлөвлөн зохион байгуулна.

4.4. Эхний бүлэг дуудлагаар ажиллаж байгаа үед дараагийн дуудлагаар ажиллах “Бэлтгэл”, “Нэмэлт”, “Нөөц” бүлгийг аврах анги, салбарын захирагч тодотгоно.

4.5. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээлэл, дуудлагын дагуу газар орон дээр хүрэлцэн очсон Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь мэдээлэл /голомтын бүсийг тогтоох, ослын шалтгаан, урьдчилсан таамаглал, үүсэж болзошгүй хоёрдогч хор уршиг, нэмэлтээр ажиллах томилгоот орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгсэл, харилцан ажиллагааг тодотгох гэх мэт/-ийг цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.6. Энэ журмын 4.5-д заасан мэдээллийг цуглуулснаар ажиллагааны дараалал, төлөвлөгөө, үүрэг, аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгааг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч ажиллагаанд оролцогч бүрэлдэхүүнд танилцуулна.

4.7. Эрэн хайх, аврах ажиллагаанд 2 бүлэг оролцох бол салбарын захирагч, 4 ба түүнээс дээш бүлэг оролцох ажиллагааг аврах ангийн захирагч, 2 ба түүнээс дээш аймгийн Онцгой байдлын газар ажилласан тохиолдолд бүсийн төвийн захирагч удирдан зохион байгуулна.

4.8. Эрэн хайх, аврах ажиллагааг ослын голомтод аль ойр байгаа нутгийн захиргаа, онцгой байдлын байгууллага харьяалал болон нутаг дэвсгэрийн хилийн цэсээс үл хамааран зохион байгуулна.

4.9. Аврах бүлэг тухайн нутаг дэвсгэрт эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах үед нутаг дэвсгэр дэх Онцгой байдлын газар, хэлтэст мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд дэмжлэг авна.

4.10. Хаана, хэн, юу осолдсон нь тодорхойгүй болон нотлогдоогүй мэдээллээр эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхгүй.

4.11. Эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэж байгаа аврах бүлэг улсын хил нэвтэрч ажиллах тохиолдолд хоёр талын онцгой байдал, хил хамгаалах, гадаад харилцааны асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран ажиллана.

4.12. Энэ журмын 4.11-д заасан хил хамгаалах, гадаад харилцааны асуудал эрхэлсэн байгууллагатай Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж ажиллана.

4.13. Аварсан, осолдсон нэрвэгдэгсдийг хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллага /амьд, бэртэж гэмтээгүй үед ар гэрт эсхүл нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд/-д шилжүүлэн өгнө.

4.14. Гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг мэргэжил шаардагдахаас бусад аюул багатай газар орон дээр, Онцгой байдлын байгууллагын бүрэлдэхүүнийг аюултай, хүндрэлтэй газар орон дээр үүрэг гүйцэтгүүлэхээр зохион байгуулна.

4.15. Тухайн нутаг дэвсгэр дэх нутгийн захиргааны байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрт эрэн хайх, аврах ажиллагаа явуулж байгаа эрэн хайх, аврах бүлэгт дэмжлэг үзүүлнэ.

4.16. Эрэн хайх, аврах ажиллагаанд агаарын хөлөг, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, эрэлч нохой, эрэн хайх, аврах техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас багаж хэрэгсэл ашиглан зохион байгуулахдаа нисэх багийн бүрэлдэхүүн болон нисгэгчгүй нисэх төхөөрөмж хариуцагч техникч, мэргэжилтэн, нохой хөтлөгчийг тухайн эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь шууд удирдлагадаа авч, хамгийн оновчтой газар оронд эрэн хайх, аврах ажиллагааг явуулна.

4.17. Энэ журмын 4.16-д заасан агаарын хөлөг, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, эрэлч нохой, эрэн хайх, аврах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтыг тухайн хариуцагч нисэх баг, техникч, мэргэжилтэн, нохой хөтлөгч нар холбогдох хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг баримталж бүрэн хариуцна.

4.18. Тухайн нутаг дэвсгэр дэх Онцгой байдлын байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй болсон тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нь зэргэлдээ аймгийн Онцгой байдлын газрын даргатай зөвшилцөн хүч нэмэгдүүлэх, Үндэсний аврах бригад, Агаараас эрэн хайх, аврах анги, Уул уурхайн аврах анги, Эрэлч нохойн нэгж болон орон нутгийн 2 ба түүнээс дээш бүлгийг томилох асуудлыг Онцгой байдлын ерөнхий газар /шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч/-т мэдэгдэж Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар шийдвэрлүүлнэ.

4.19. Эрэн хайх, аврах бүлэг гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлагаар байнгын байрлалаас гарсан цагаас буцаж ирэх хүртэлх цагаар ажиллагааны хугацааг тооцно.

4.20. Эрэн хайх, аврах ажиллагааны үргэлжлэх хугацааг газар орны байршил, байгаль, цаг агаар, үүссэн нөхцөл байдлыг харгалзан эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч харьяалах эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

4.21. Эрэн хайх, аврах ажиллагаа эхэлснээс хойш 72 цагийн дотор төөрсөн, сураггүй болсон иргэнийг олоогүй тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь ар гэрийнхэн болон эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагчтай зөвшилцөн үргэлжлүүлэх, хойшлуулах /түр/ эсхүл зогсоох шийдвэр гаргана.

4.22. Эрэн хайх, аврах ажиллагааг эхэлсэн цагаас хойш 144 цаг буюу 6 дахь хоногоос эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, ахлах удирдагчтай; 216 цаг буюу

9 дэх хоногоос эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч, ерөнхий удирдагчтай; 288 цаг буюу 12 дахь хоногоос эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч бүсийн төвийн захирагчтай; 360 цаг буюу 15 дахь хоногоос бүсийн төвийн захирагч, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргатай; 432 цаг буюу 18 дахь хоногоос онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн үргэлжлэх хугацааг тогтооно.

4.23. Аюулт үзэгдэл, ослын төрөл, байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 4.22-т заасан хугацааг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн саналыг үндэслэн өөрчилж болох бөгөөд шийдвэрлэх албан тушаалтны дараалал өөрчлөгдөхгүй.

4.24. Эрэн хайх, аврах ажиллагааг сэргээх, үргэлжлүүлэх тухай ар гэрийнхэн болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнаас /бичгээр/ ирүүлсэн хүсэлтийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга шийдвэрлэнэ.

4.25. Эрэн хайх, аврах ажиллагаанд өндөр настай, бага насны хүүхэдтэй эсхүл жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцгийг татан оролцуулахыг хориглоно.

4.26. Энэ журмын 4.25-т заасан үндэслэлийг тухай иргэн эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчид мэдэгдэх үүргийг хүлээнэ.

4.27. Энэ журмын 4.26-д заасан үүргийг тухайн иргэн хэрэгжүүлээгүй бол, түүнээс үүдэн гарах эрсдэлийг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч хүлээхгүй болно.

4.28. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогч хүн нэг бүр бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүйн тавигдах шаардлагыг хангасан байх бөгөөд эрүүл мэндийн анхан шатны үзлэгээр холбогдох шаардлага хангахгүй бол ажиллагаанд эс оролцуулах шийдвэрийг томилогдон ажиллаж буй эмч, сэтгэл зүйч, эмнэлгийн зааварлагч нар гаргана.

4.29. Энэ журмын 4.28-д заасныг хэрэгжүүлж буй эмч, сэтгэл зүйч, эмнэлгийн зааварлагчийн тавьж буй шаардлагыг хүн нэг бүр биелүүлэх үүргийг хүлээнэ.

4.30. Голомтод хүрэлцэн очсон бүрэлдэхүүн дуудлага, мэдээллийн бүртгэл, тодруулга, явцад ослын шинж байдал нь гадны нөлөөтэй, гэмт хэргийн шинж

чанартай байж болзошгүй тохиолдолд хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллагын оролцоотойгоор дараах зарчмаар ажиллах. Үүнд:

4.30.1. эрэн хайх, аврах ажиллагаанд нэн тэргүүнд болон хоёрдох, гуравдах хайх чиглэл, талбайг сонгох;

4.30.2. сонгосон чиглэл, талбайд эрэн хайх, аврах ажиллагаа үр дүнтэй зохион байгуулагдсан эсэхэд хяналт тавих;

4.30.3. эрэн хайх, аврах ажиллагаанд төөрсөн, сураггүй болсон иргэний гэр бүлийн хамаарал бүхий хүн оролцож байгаа бол тухайн хүний сэтгэл зүйн байдлыг харгалзан үзэх үүднээс ажиллагаанд оролцуулахгүй байхад анхаарах;

4.30.4. эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчийн сэтгэл санааны байдал, айдас, түгшүүртэй байгаа эсэхэд хяналт тавих;

4.30.5. зохион байгуулж байгаа үйл ажиллагааг хөндлөнгөөс иргэн болон албан тушаалтан шүүмжилж байгаа эсэхэд хяналт тавих, шалтгааныг харгалзан үзэх;

4.30.6. ажиллагаанд оролцогч нар тогтоосон чиглэлээс өөр чиглэлд ажилласан эсэхэд хяналт тавих;

4.30.7. төөрсөн, сураггүй болсон иргэний өмсөж явсан хувцас, биед байсан эд зүйлс, нотлох баримт олдсон, илэрсэн үед нэг бүрчлэн бүртгэх, түүнд гар хүрсэн, хөдөлгөсөн эсэхэд хяналт тавих;

4.30.8. буцалтгүй нэрвэгдэгч эсхүл түүний өмсөж явсан хувцас, биед байсан эд зүйлс, нотлох баримт олдсон, илэрсэн үед хамгаалалтад авах, түүний ойр орчим газарт үзлэг, шалгалт хийх;

4.30.9. буцалтгүй нэрвэгдэгч олдсон үед бусад ажиллагаанд оролцогч нарын хөдөлгөөнийг хязгаарлах, тэдний аюулгүй байдлыг хангах үүднээс эгүүлэн татах ажиллагаа /албаны тусгай дохиогоор харьцах/-г зохион байгуулах;

4.30.10. буцалтгүй нэрвэгдэгчийн холбогдолтой мэдээ, мэдээлэл, дүрс бичлэг, гэрэл зургийг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн томилсон алба хаагчаас бусад хүн албаны бус хэрэгслээр баримтжуулахгүй байх, хяналт тавих;

4.30.11. шаардлагатай тохиолдолд гэрчээс үүссэн нөхцөл байдлын тодруулах асуулт асуухдаа өөрийн үг, дуу хоолойны өнгөнд хяналт тавьж, тухайн иргэнтэй хүндэтгэлтэй харьцах;

4.30.12. шаардлагатай тохиолдолд буцалтгүй нэрвэгдэгчийн бие /зориулалтын уутанд хийх¹/-д хүрэх, харьцахдаа эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн зөвшөөрлөөр аврагч нь халдвар хамгааллын нэг удаагийн хувцас, бээлий, малгай, амны хаалттайгаар цагдаагийн байгууллагын алба хаагчийн хамт ажиллана.

Тав. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогч албан тушаалтны эрх, үүрэг

5.1. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн эрх, үүрэг

5.1.1. эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь дараах эрхтэй:

а) эрэн хайх, аврах ажиллагааны үед тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр хангагдах;

б) эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч гамшиг, аюулт үзэгдэл, ослын холбогдолтой мэдээллийн дагуу цагийн байдлыг холбогдох нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан болон гамшгаас хамгаалах улс, орон нутгийн албаны мэргэжлийн ангийн даргаас тодруулах;

в) бүлгийн бүрэлдэхүүн болон нутгийн захиргаанаас томилогдсон мэргэжлийн ангийн дарга буюу холбогдох албан тушаалтны үйл ажиллагааг мэргэжлийн дагуу удирдан чиглүүлэх;

г) эрэн хайх, аврах ажиллагаанд саад учруулсан этгээдийг хууль сахиулах байгууллагад мэдэгдэж хариуцлага хүлээлгэх;

д) эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг сонгон дайчлан оролцуулах;

е) эрэн хайх, аврах ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн техник хэрэгслийг татан оролцуулах;

ё) нэрвэгдэгчийн талаарх мэдээллийг цуглуулахдаа иргэдээс асуух, лавлах /гэрчийн мэдүүлэг/ журмаар явуулна;

ж) гэрчийн мэдүүлгээр нэрвэгдэгчийн байгаа газар, тэдгээрийн тоо, богино хугацаанд очих зам, чиглэл, нэрвэгдэгсдийн биеийн байдал, ослын голомтод хоёрдогч аюултай хүчин зүйлс байгаа эсэхийг асууж тодруулах;

¹ СХЗГ-ын даргын 2018 оны С/06 дугаар тушаалаар батлагдсан “MNS 6740:2018 Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага” Үндэсний стандартын Ё хавсралтын 21 дэх хэсэгт

з) буцалтгүй нэрвэгдэгч /амьд биш нэрвэгдэгч буюу хүний цогцос/-ийг эрэн хайж байгаа үед нэмэлт ослын дуудлага ирвэл эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр бүлгийн бүрэлдэхүүнийг бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлж эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх.

5.1.2. эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь дараах үүрэгтэй:

а) аврах бүлгийн бие бүрэлдэхүүнийг эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажилд сургаж, бэлтгэх;

б) ослын хор уршгийг арилгах төлөвлөгөө боловсруулах, ажиллагаанд шаардагдах төсвийг тооцоолон гаргаж, холбогдох баримт, бичгийг бүрдүүлэх;

в) аврах бүлгийн бие бүрэлдэхүүний тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн иж бүрдлийг үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгох, үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

г) ослын голомтод тээврийн хэрэгсэл хүрэлцэн очих зам гарц гаргах үүрэг гүйцэтгэж байгаа аврагчдын аюулгүй ажиллагаанд хяналт тавих;

д) ослын голомтод үүссэн цагийн байдалтай уялдуулж шаардлагатай хүч, хэрэгслээр хангах ажиллагааг зохион байгуулах;

е) шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед холбогдох хууль, хяналтын байгууллагад хэргийн газарт үзлэг хийх боломжийг хангах ажлыг зохион байгуулах;

ё) нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах;

ж) эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч үүссэн цагийн байдал түүний явцад гарсан өөрчлөлтийн хамт байр зүйн зураг дээр тактикийн таних тэмдэг, тайлбарлах бичгийн тусламжтай буулган зурж хөтөлнө;

з) эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож буй албан хаагчид, иргэдийн аюулгүй байдлыг хангах, зааварчилгаа өгөх, хяналт тавих;

и) эрэн хайх, аврах ажиллагааг явуулах газар орныг судлах, чиглэл, хяналт тогтоох өндөрлөг, тэмдэгтийг тодорхойлох;

й) газар орны баримжаалал, хөдөлгөөний чиглэл, харилцах дохионууд, цугларах газар, хоорондын зай ба хайгуулын талбайн хязгаарыг тогтоох;

к) нөхцөл байдлын талаарх үнэн бодит мэдээллээр харьяа газар, хэлтэст тогтмол мэдэгдэж байх;

л) эрэн хайх, аврах бүрэлдэхүүний хоноглох газар, байр, сууц, хоол хүнсийг хангуулсан байх, шаардлагатай тохиолдолд дээд шатны удирдлага болон сум, дүүргийн удирдлагатай зөвшилцөн шаардлагатай зүйлсээр хангуулах;

м) эрэн хайх, аврах ажиллагааны үед удирдлагадаа ажиллаж байгаа бүрэлдэхүүнээс тогтмол мэдээлэл авч учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

н) шаардлагатай нөхцөлд хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг, туслалцаа авах;

о) агаарын хөлгийн нисэх багийн бүрэлдэхүүнд эрлийн солбицол болон мэдээллийг үнэн зөв өгөх;

ө) ослын шалтгаан, нөхцөл байдал болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аврах ажиллагааны даалгавар, тэмдэглэл, илтгэх хуудас, ажиллагааны ярилцлагыг зохион байгуулж харьяа бүтцийн нэгжийн даргад танилцуулах.

5.2. Аврагчийн эрх, үүрэг

5.2.1. аврагч нь дараах эрхтэй:

а) эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх;

б) эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;

в) бүлгийн дарга (эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч)-ын шийдвэрээр тухайн сум, дүүргийн мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэдийг хариуцан эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах;

г) эрэн хайх, аврах ажиллагааны талаар санал, гаргах;

д) яаралтай ажлын шаардлагаар эзэмшигчийн зөвшөөрлөөр унаа, мотоцикл, техник, эд хэрэгслийг авч ашиглах;

е) араатан амьтан дайрах, болзошгүй тохиолдолд өөрийгөө хамгаалах тусгай хэрэгсэл /галт зэвсэг, хуйтай хутга, нулимс асгаруулагч, дуу чимээ үүсгэгч, дохио өгөгч/ ашиглах.

5.2.2. аврагч нь дараах үүрэгтэй:

а) бүлгийн дарга (эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч)-ын өгсөн үүрэг даалгаврыг зааварчилгааны дагуу гүйцэтгэх;

б) эрэн хайх, аврах ажиллагааг мэргэжлийн түвшинд заасан чиглэлийн дагуу шуурхай зохион байгуулах;

в) эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцан түүнийг зориулалтын дагуу ашиглах ур чадвар эзэмшсэн байх;

г) байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үеийн бэрхшээлийг давах мэргэжлийн болон бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлтэй байх;

д) өөрийн болон нөхрийнхөө аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж аюул тулгарсан үед тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

ё) хариуцсан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийг өөрийн биед тааруулан бэлтгэсэн байх;

ж) аварсан, осолдсон хүний эд зүйлс олдвол түүнийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

з) эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж, аврагч хоорондын тусгай дуут болон дуугүй дохиогоор харьцаж ажиллах;

и) ажиллагааны явцад аврагч бүр газар орны онцлог шинж байдлыг хянамгай харах ба нэн тэргүүнд нэрвэгдэгсэд байж болзошгүй газрыг тогтоох /барилга байгууламжийн нуранги, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, хугарсан мод, өндөр өвс, бут, сөөг, овоорсон навч, цасан хунгар, мөс, өндөр дов, толгод, хад, асга, агуй, нүх, гуу жалга, зориуд тавьсан тэмдэг дохиог г.м/;

й) газар орон дээр хөдөлгөөн үйлдэхдээ зүг чиг тодорхойлох багаж, байр зүйн зураг ашиглах, болон тохирсон дохиог бүрэлдэхүүнд өгөх, зайлшгүй тохиолдолд аюулгүйн, анхааруулга, заах, зааварчилгааны тэмдэг үлдээх.

5.3. Эмч, сэтгэл зүйч (эмнэлгийн зааварлагч)-ийн эрх, үүрэг

5.3.1. эмч, сэтгэл зүйч (эмнэлгийн зааварлагч) нь дараах эрхтэй:

а) эрэн хайх, аврах ажиллагаанд эрүүл мэндийн шаардлагаар тэнцэхгүй алба хаагч болон сайн дурын хэсэг, иргэнийг үйл ажиллагаанаас чөлөөлөх;

б) эрэн хайх, аврах ажиллагааны үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг зөөвөрлөх үед аврагч нарыг ажиллуулах;

в) анхны тусламжийн багаж, хэрэгсэл, ороох, боох материал, эм, эмийн хэрэгслээр бүрэн хангагдсан байх.

5.3.2. эмч, сэтгэл зүйч (эмнэлгийн зааварлагч) нь дараах үүрэгтэй:

а) эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох алба хаагчдад эрүүл мэндийн үзлэг хийсэн байх;

б) эрэн хайх, аврах ажиллагааны явцад оролцогч нарын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, нэрвэгдэгсэд болон түүний ар гэрт сэтгэл зүйн, эмнэлгийн тусламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлэх;

в) шаардлагатай анхны тусламжийн хэрэгслийг эрэн хайх, аврах ажиллагаанд явахдаа бүрэн авч явах;

г) гамшиг, аюулт үзэгдэл, осолд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн сэтгэхүйн хямрал, үр дагаврыг бууруулах зорилгоор шаардлагатай тохиолдолд гэрч хохирогчийг хамгаалалтад авхуулах саналыг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчид танилцуулах.холбогдох арга хэмжээг авах.

5.4. Аврагч-жолооч, холбоочны эрх, үүрэг

5.4.1. аврагч-жолооч, холбоочин нь дараах эрхтэй:

а) тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэлд гарсан гэмтлийг засварлах талаар бүлгийн дарга (эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч)-д мэдэгдэж шаардлагатай сэлбэг, хэрэгслээр хангагдах, шатахуун тосолгооны материалын тооцоог гаргаж цэнэглэх, нөөцийг бүрдүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах;

б) хариуцсан техник, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх үед бүлгийн даргад мэдэгдэж аврагч нарын тусламж, дэмжлэгийг авах;

в) биеийн эрүүл мэндийн байдалд өөрчлөлт орсон, хэт удаан хугацаагаар автомашин жолоодсон тохиолдолд эрүүл мэндийн тусламж авах.

5.4.2. аврагч-жолооч, холбоочин нь дараах үүрэгтэй:

а) эрэн хайх, аврах ажиллагааны өмнө өөрийн хариуцсан техникийн засвар үйлчилгээг хийж бэлэн байдлыг хангасан байх;

б) аврах бүлгийн бүрэлдэхүүнийг шаардлагатай газар оронд аюулгүй зам, чиглэлээр замын хөдөлгөөний дүрмийг баримтлан тээвэрлэн хүргэх болон байнгын байрлалд буцах;

в) хариуцсан холбооны хэрэгслийг бүрэн хариуцаж аврах ажиллагааны удирдагчийн өгсөн зүг чиг, үүргийн дагуу мэдээллийг харьяа аврах анги, салбарт дамжуулах;

г) бартаат зам, газар орныг урьдчилан тооцоолж эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчид танилцуулж чиглэлийг өөрчлөх, шаардлагатай тохиолдолд зорчигчдыг буулган аюулгүй байдлыг хангасны дараа саадыг даван туулах;

д) эрэн хайх, аврах ажиллагааны үед техник, багаж хэрэгсэлд доголдол илэрсэн тохиолдолд шуурхай засах, ямар арга хэмжээ авсан талаар дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулж нотломж үйлдэх;

е) ослын голомтод аюултай бүсийн тэмдэглэгээний туузыг бүлгийн даргын шийдвэрийн дагуу татаж, хяналт тавих;

5.5. Гамшгаас хамгаалах албаны эрэн хайх, аврах ажиллагаатай холбоотой удирдлага, зохицуулалтыг Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн баталсан “Гамшгаас хамгаалах улсын албаны нийтлэг журам”-д зааснаар;

5.6. Мэргэжлийн ангийн эрэн хайх, аврах үйл ажиллагаатай холбоотой удирдлага, зохицуулалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/379 дүгээр тушаалаар батлагдсан “Мэргэжлийн ангийн дүрэм”-д зааснаар;

5.7. Нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэдийн эрэн хайх, аврах үйл ажиллагаатай холбоотой

удирдлага, зохицуулалтыг Гамшгаас хамгаалах тухай хууль болон Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 24 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, мөн сайдын 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 38 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/185 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”-д зааснаар;

5.8. Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн дагуу эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцож байгаа Төрийн цэргийн байгууллагын томилгоот хүч хэрэгсэл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар зарлигаар шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм”-ийн тавдугаар бүлэг, 98 дугаар зүйлд зааснаар;

5.1. Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн дагуу эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцож байгаа Цагдаагийн байгууллагын томилгоот бүрэлдэхүүн, алба хаагч нь “Цагдаагийн албан тухай хууль”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д зааснаар тус тус хэрэгжүүлж ажиллана.

Зургаа. Эрэн хайх, аврах ажиллагааны үе шат, тактик ажиллагаа

6.1. Мэдээлэл хүлээн авах. Үүнд:

- 6.1.1. дуудлагын талаарх товч мэдээлэл;
- 6.1.2. холбоо тогтоох (мэдээлэл өгөгчийн нэр, хаяг, утасны дугаар);
- 6.1.3. ослын талаарх мэдээлэл (байршил, эхэлсэн огноо, цаг, минут);
- 6.1.4. ослын газарт хүрэлцэн очих зам, маршрут;
- 6.1.5. нэрвэгдэгсдийн биеийн байдал.

6.2. Мэдээллийг хүлээн авсан төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага нь дараах ажиллагааг явуулна. Үүнд:

- 6.2.1. мэдээллийг нягтлан шалгах;
- 6.2.2. мэдээллийн дагуу байр зүйн зураг дээр тэмдэглэх;
- 6.2.3. шаардлагатай мэдээллийг цуглуулах;
- 6.2.4. ослын үеийн болзошгүй (2-оос илүү) хувилбарыг тооцоолох;

- 6.2.5. эрэн хайх, аврах бүлгийг томилох;
- 6.2.6. хайлтын бүсийг тогтоох;
- 6.2.7. эрэн хайх, аврах ажиллагааны бүх мэдээллийг нэгтгэн дүгнэх.

6.3. Голомтод хүрэлцэн очих. Үүнд:

- 6.3.1. ослын голомт руу хөдөлгөөн үйлдэх;
- 6.3.2. ослын голомт руу шуурхай хүрэлцэн очих зам, маршрутыг тогтоох;
- 6.3.3. нөөц зам, маршрутын хувилбарыг тооцох;
- 6.3.4. байр зүйн зураг болон байршил тогтоогч /GPS/-д тэмдэглэх;
- 6.3.5. болзошгүй нөхцөлийг тооцох;
- 6.3.6. дээд шатны байгууллагад мэдээллийг тогтмол дамжуулах, хүлээн авах.

6.4. Төлөвлөх (цагийн байдлыг үнэлж шийдвэр гаргах). Үүнд:

- 6.4.1. шуурхай удирдлагын байр /штаб/-ыг байгуулах;
- 6.4.2. шаардлагатай нэмэлт хүч, хангалтын тооцоог хийх;
- 6.4.3. шаардлагатай тохиолдолд сайн дурын хэсэг, иргэдийг эрэн хайх, аврах ажиллагаанд татан оролцуулах;
- 6.4.4. эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдод үүрэг даалгавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх.

6.5. Шуурхай арга хэмжээг авах. Үүнд:

- 6.5.1. голомтын бүс орчмын байгаль, цаг агаарын нарийвчилсан мэдээг авах;
- 6.5.2. голомтын бүсэд аврагчдыг томилгоожуулах;
- 6.5.3. бүлэг, аврагч нарт даалгаврыг өгөх;
- 6.5.4. ажиллагааны бүрэлдэхүүний бүтцийн бүдүүвчийг гаргах;
- 6.5.5. байр зүйн /даргын ажлын/ зураг хөтлөх;
- 6.5.6. ажиллагааны тэмдэглэл хөтлөх.
- 6.5.7. нэрвэгдэгсдийг хүлээн авах, тээвэрлэх ажиллагааг зохион байгуулах.

6.6. Ажиллагааг дуусгах. Үүнд:

6.6.1. гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэдийн эрэн хайх, аврах ажиллагааны хүч хэрэгслийн бүртгэл, жагсаалтыг гаргасан байх;

6.6.2. нэрвэгдэгсэд болон буцалтгүй нэрвэгдэгчийн талаарх мэдээллийг нэгтгэсэн байх;

6.6.3. ашигласан техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн зардлын тооцоог гаргасан байх;

6.6.4. эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийг ачаалан бэлтгэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган голомтоос байнгын байрлал руу хөдөлгөөн үйлдэх.

6.7. Энэ журмын 4.8-д заасан аюултай эсхүл хүндрэлтэй нөхцөл байдлыг дараах тохиолдолд тооцож болно. Үүнд:

6.7.1. хүчтэй цасан болон шороон шуурга;

6.7.2. ой, тайга, уулархаг, хад асга, хавцал, агуй, бартаатай болон эзгүй тал хээр, говийн нөхцөлд;

6.7.3. их хэмжээний барилга, ил болон далд уурхайн нуранги үүссэн үед;

6.7.4. их цас унасан үед;

6.7.5. их хэмжээний бороо, үерийн үед;

6.7.6. усанд осолдсон үед;

6.7.7. тэсэрч дэлбэрэх болон цацраг, хими, биологийн хорт бодис алдагдсан үед химийн салбар, томилгоот бүлэг ажиллах;

6.7.8. хөрсний гулгалт;

6.7.9. өндөр уулын бүсэд;

6.7.10. өндөр барилга байгууламж дээр ажиллах;

6.7.11. бүх төрлийн тээврийн хэрэгслийн ослын үед;

6.7.12. бусад /гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал тогтоогдоогүй бөгөөд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирч болзошгүй үед онцгой байдлын байгууллагаас дэмжлэг хүсэх/.

6.8. Энэ журмын 6.7-д заасан аюултай, хүндрэлтэй нөхцөл байдлын үед онцгой байдлын байгууллагаас эрэн хайх, аврах ажиллагааны холбогдох стандарт, дүрэм,

журам, зааврын дагуу томилгоот мэргэжлийн бэлтгэгдсэн бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

6.9. Агаарын хөлөг болон өргөгч төхөөрөмжтэй эрэн хайх, аврах ажиллагааг дараах тохиолдолд зохион байгуулахыг хориглоно. Үүнд:

- 6.9.1. далайн төвшнөөс 5000 метрээс дээш газар;
- 6.9.2. агаарын хөлгийн техникийн эвдрэл, гэмтэл учирсан;
- 6.9.3. цаг агаарын мөстөлттэй;
- 6.9.4. үзэгдэх орчин 3500 метрээс бага;
- 6.9.5. Агаарын температур -35 градусаас дээш үед.

6.10. Байгаль, цаг агаар, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан бүлгийн бүрэлдэхүүнийг чиглүүлэх газарчныг тухайн орон нутгаас томилуулж, ажиллуулна.

6.11. Байгалийн гаралтай онц аюулт үзэгдэл болон бусад гамшиг ослын үед буцалтгүй нэрвэгдэгч, тусламж хэрэгтэй хүн байх магадлал бүхий газар орныг урьдчилан тооцоолж, чиглэлийг шалгана.

6.12. Эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэж буй аврагч нь удирдагчаас тогтоосон цагт ажиллагааны явцыг удирдагчид тогтмол мэдээлэх, үүссэн нөхцөл байдлын талаар танилцуулж чиглэл авна.

6.13. Эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэж буй аврагчид өөрсдийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ бусад аврагч нарт аюул тулгарсан үед туслахад байнга бэлэн байна.

6.14. Төөрсөн, сураггүй болсон иргэнийг эсэн мэнд олсон даруй аврах ажиллагааны удирдагчид яаралтай мэдэгдэн нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, тайвшруулах арга хэмжээ авна.

6.15. Төөрсөн, сураггүй болсон иргэн /нас барсан/ тохиолдолд газар орныг хамгаалалтад авч аврах ажиллагааны удирдагчид яаралтай мэдэгдэж хууль хяналтын байгууллагад хүлээлгэн өгнө.

6.16. Энэ журмын 6.7-д заасан аюултай эсхүл хүндрэлтэй нөхцөл байдлын үед ажиллагааны удирдагчийн шийдвэрээр эрэн хайх, аврах ажиллагааг түр зогсоох эсхүл ажиллагааг явуулахгүй цуцалж болно.

6.17. Энэ журмын 6.16-д заасан эрэн хайх, аврах ажиллагааг түр зогсоох, ажиллагаагүй явуулахгүй цуцлах шийдвэр гаргасан тохиолдолд эрэн хайх, аврах

ажиллагааны удирдагч нь үндэслэл, дүгнэлтийг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчид илтгэх хуудсаар танилцуулна.

6.18. Эрэн хайх, аврах ажиллагааны явц, дараах үеүдэд эрүүл мэндийн, хүний эрх, гэр бүл, хүүхэдтэй хамаарал бүхий байгууллага болон онцгой байдлын байгууллагын мэргэжлийн эмч-сэтгэл зүйч нар нэрвэгдэгсдэд, түүний ар гэрийнхэнд, шаардлагатай тохиолдолд ажиллагаанд оролцсон хүн нэг бүртэй уулзалт, ярилцлагыг зохион байгуулж ажиллана.

Долоо. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа,
мэргэжлийн сургалт, дадлага

7.1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа:

7.1.1. Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, зааврыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, харьяа нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан (техник, багаж хэрэгсэл) мэргэжилтэн өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

7.1.2. аврах ажиллагааны холбогдох журмыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврын дагуу аврах анги, салбарт захирагч нар, аврах бүлэгт бүлгийн дарга хэрэгжүүлнэ.

7.1.3. гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хангагдаагүй тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхийг хориглоно.

7.1.4. буцалтгүй нэрвэгдэгчийг эрэн хайх, аврах ажиллагаа болон албаны тусгай зориулалтын автомашинаар болон аврах бүлгийн бүрэлдэхүүний хамт зөөвөрлөхийг хориглоно.

7.1.5. эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрт болон ажиллагаанд оролцож буй алба хаагч, сайн дурын хэсэг, иргэдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулах, гаргасан шийдвэрийг эсэргүүцэх, ажиллагааны бүс рүү зөвшөөрөлгүй нэвтэрхийг хатуу хориглоно.

7.1.6. байнгын байрлалд үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн, бэлтгэл томилгоот аврах бүлгийг эрэн хайх, аврах ажиллагаа, албаны тусгай мэргэжлийн сургалт, дадлага, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээс бусад үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.

7.2. Мэргэжлийн сургалт, дадлага:

7.2.1. эрэн хайх, аврах ажиллагааны төрөл мэргэжлийн албаны тусгай мэргэжил олгох дотоод, гадаадын сургалтыг Онцгой байдлын ерөнхий газраас шийдвэрлэнэ.

7.2.2. эрэн хайх, аврах ажиллагааны мэргэжлийн давтан сургалт, дадлагыг бүс, орон нутгийн Онцгой байдлын байгууллага жил бүрийн төлөвлөгөөнд тусган холбогдох эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

7.2.3. аврах анги, салбарын захирагч нь эрэн хайх, аврах ажиллагааны сургалт, дадлагыг улирал болон аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын давтамж, магадлалыг тооцон улирал тутамд төлөвлөгөөт хэлбэрээр зохион байгуулна.

7.2.4. эрэн хайх, аврах ажиллагааны сургалт, дадлагыг хөтөлбөрийн дагуу онол, дадлага хэлбэрээр зохион байгуулна.

7.2.5. бүх төрөл (шөнийн, дулаан мэдрэгчтэй)-ийн нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийг 3-аас доошгүй жил ажилласан, тусгай сургалтад хамрагдсан алба хаагч ажиллуулна.

7.2.6. гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага болон сайн дурын хэсэг, иргэдийн эрэн хайх, аврах ажиллагааны сургалт, дадлагыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцан зохион байгуулна.

7.3. Бусад байгууллагатай хамтран ажиллах харилцан ажиллагааны сургалт, дадлага:

7.3.1. Онцгой байдлын байгууллага нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад ослын шинж байдал нь гадны нөлөөтэй, гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй тохиолдолд хууль хяналтын болон эрүүл мэндийн, хүний эрх, гэр бүл, хүүхэдтэй хамаарал бүхий асуудал эрхэлсэн байгууллагаас дэмжлэг авах, шаардлагатай тохиолдолд тэдэнд ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх, харилцан ажиллагааны чиглэлээр албаны тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг дурдагдсан байгууллагууд хамтран зохион байгуулна.

7.3.2. төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага хоорондын харилцан ажиллагааны тусгай сургалтуудыг тэргүүлэгч байгууллагын чиглэлийн төлөвлөгөөний дагуу хамтран зохион байгуулна.

Найм. Санхүү, ар тал хангалт

8.1. Эрэн хайх, аврах ажиллагааны эхний 72 цагийн хангалт /хүнс, шатахуун, багаж хэрэгсэл/-ыг тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллага хариуцана.

8.2. Аврах бүлгийг сэлгэх эсхүл дэмжлэгээр ирж байгаа аврах бүлэг нь 72 цаг бие даан үүрэг гүйцэтгэх чадамжтай байна.

8.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн анги, нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэд нь эрэн хайх, аврах ажиллагааны 72, 144, 216, 288 цаг ажиллах бүх төрөл /хүнс, шатахууны гэх мэт/-ийн нөөцийг холбогдох журмын дагуу бүрдүүлсэн байна.

8.4. Энэ журмын 8.3-д заасан нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэд нь эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа бол гаргасан зардлаа бүрэн хариуцна.

8.5. Энэ журмын 6.7.12-д заасан болон гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал үүсээгүй боловч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага онцгой байдлын байгууллагад хүсэлт гаргасан тохиолдолд төлбөртэй үйлчилж болох бөгөөд тусгай журмаар зохицуулна.

8.6. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчоос болон бусад иргэн, байгууллагаас үзүүлж буй буцалтгүй тусламж, хандив, дэмжлэг нь тусгай журмаар олголт, хуваарилалт нь зохицуулагдана.

8.7. Энэ журмын 8.6-д заасан буцалтгүй тусламж, хандив өгөгч нь өөрөө болон хамаарал бүхий байгууллагын оролцоотойгоор хуваарилан олгох ажлыг зохион байгуулж болно.

Ес. Хяналт, хариуцлага

9.1. “Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтэд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

болон гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн анги, нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэд хамтран хяналт тавьж ажиллана.

9.2. Аврах ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулж буй эдгээд тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэлд гэмтэл учруулсан тохиолдолд тухайн иргэн, байгууллагаар нөхөн төлүүлнэ.

9.3. Энэ журмын 9.2 дахь заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол “Төрийн албаны тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-д заасан холбогдох хариуцлага оногдуулна.

9.4. Энэ журмын 7.1.5, 8.6, 9.3, 10.2 дахь заалтыг тусгайлан болон энэ журмыг бүхэлд нь гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавьж ажиллана.

Арав. Бусад

10.1. “Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам”-ыг боловсронгуй болгох зорилгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн анги, нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх саналаа Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бичгээр ирүүлнэ.

10.2. Төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүргийн байгууллага, гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн анги, нийгмийн тусын тулд үйлчилдэг, тусгайлан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед томилогдон ажиллах хүч хэрэгслийн чадамжтай төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг, иргэд нь хувийн болон байгууллагын цахим хаягаар эрэн хайх, аврах үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг ажиллагааны ахлах, ерөнхий удирдагчийн зөвшөөрөлгүй олон нийтийн цахим сүлжээнд байршуулахгүй албан ёсны нэг сувгаар холбогдох эрх бүхий алба хаагч, ажилтан олон нийтэд мэдээлж ажиллах зарчмыг баримтална.

10.3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтанд төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүргийн байгууллагаас эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр томилогдон оролцож байгаа цэргийн анги, салбар буюу багийг захируулахыг хориглоно.

10.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлалд үндэслэн, улс, орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулахдаа шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын шийдлийг нэвтрүүлэх, судалгаа, туршилтын ажлыг холбогдох салбар, байгууллагуудтай онцгой байдлын байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

...oOo...